

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны __ сарын __ өдөр

Дугаар __

Төрийн ордон, Улаанбаатар хот

“Импортын барааны гаалийн албан
татварын хувь, хэмжээ батлах тухай”
тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 07 дугаар бүлгийн Хүнсний ногоо, зарим ургамлын үндэс булцуу “20 хүртэл” гэснийг “30 хүртэл” гэж, мөн бүлгийн Төмс, Сонгино /сармис, улаан лооль, өргөст хэмх/, Байцаа, Шар лууван, Шар манжин тус бүр “20 хүртэл” гэснийг тус бүр “30 хүртэл” гэж өөрчилсүгэй.

2.Үр тариа, тосны ургамал, тэжээлийн таримал, төмс, хүнсний ногооны үрийн гаалийн албан татварын хувь, хэмжээг “0” болгосугай.

3.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан барааны үндэсний кодыг 2020 оны 08 дугаар сарын 01-ний дотор батлахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-даалгасугай.

4. Энэ тогтоолыг 2020 оны 08 дугаар сарын 01-нээс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ